



*Шүударга ёс,
хөгжил дэвшилд*

ҮНЭТ ЗҮЙЛИЙН БОЛОВСРОЛ

Хянасан:

Д.ДУЛАМСҮРЭН

Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комисsar

Нэлгэсэн:

Б.СҮРЭНЖАВ

Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комисsar

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Э.Энхтуяа

Номын формат:

Үсгийн гарнитур: Mogul Freeset

Хэвлэлийн хуудас: 4 х.х

Хэвлэсэн тоо: 3000 ширхэг

"УРАНГАР ПРЕСС" ХХК-д хэвлэв.



Өмнөх уг

Үнэт зүйл гэдгийг "хүмүүсийн хамтран амьдрах суурь нөхцөлийг бүрдүүлдэг зүйлс" гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл, хүний оршихуйн зайлшгүй хэлбэр болох нийгмийн мөн чанарыг үнэт зүйл илэрхийлдэг. Нөгөө талаас, үнэт зүйл бол нийгмийн хөгжлийн чиглүүлэгч бөгөөд нийгмийн гишүүн бүрийн эрхэм зорилго, эрхэмнэл нь байх учиртай юм.

Бид дэлхий нийтийн глобал хөгжлөөс хоцрохгүйн тулд технологи, эдийн засаг, үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр хичээн зорихын зэрэгцээ иргэдийнхээ, ялангуяа ид сурч боловсрох, сэтгэх, бүтээх насандaa явва сурагчид, оюутан залуусынхаа оюуны соёл, сэтгэлгээний хөгжил, ухамсар, хандлагыг зөв замж, чиглүүлж, дэмжиж тэтгэж байж нийгэм зүй зохицтой, тэнцвэртэй хөгжинө. Нэн ялангуяа хүний нийгмийн оршихуйн утга учир болох үнэт зүйл, ёс суртахууны талаарх мэдлэг, хүмүүжлийг залуу хүн бүрт ойлгуулж ухааруулах нь эцэг эхээс эхлээд төрийн тэргүүний хүртэл хүн бүрийн үүрэг юм.

Ирээдүйн шударга, үнэнч, хариуцлагатай нийтийн албан тушаалтан өнөөгийн залуусын дунд байгаа нь дамжиггүй. Шударга, үнэнч, хариуцлагатай байх чадварыг хүн нэг өдөр эзэмшиж, нэг л өдөр хүнд суучихдаггүй. Тэр тусмаа нэгэнт шударга бус, худал хуурмаг зан чанарт автсаны дараа үүнийг засахад бэрх. Алхам тутамдаа өөрийн дотоод

ертөнцдөө анхаарал хандуулж, өөрийгөө үнэлэн цэгнэж, суралцаж, хөгжүүлж байж шударга, үнэнч зан чанарыг төлөвшүүлнэ.

Авлигатай үр дүнтэй тэмцсэн улс орнууд авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэлээр болгон, иргэдийнхээ авлигын эсрэг боловсролд анхаарсан байдаг. Авлигатай тэмцэх газрын нэг чиг үүрэг бол олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын хор аюулыг ухуулан таниулах үйл ажиллагааг тасралтгүй явуулах явдал билээ. Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа нь авлигыг жигших үзлийг төлөвшүүлэх, иргэдийн ухамсарт суулгах ажил бөгөөд дуу, шүлэг, зураг, ном, кино, жүжиг, лекц, яриа таниулга, сургалт, хэлэлцүүлэг зэрэг олон хэлбэрээр зохион байгуулдаг.

Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан 2019 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр их, дээд сургуулийн оюутнуудад зориулан "Үнэт зүйлийн боловсрол" арга хэмжээг "UB Palace"-ын их танхимд зохион байгуулсан билээ. 3000 гаруй залуус оролцсон уг арга хэмжээнд хүрэлцэн ирж өөрсдийн эрхэмнэл, үнэт зүйлсээсээ хуваалцсан зочдын илтгэлүүдийг нэгтгэн уншигчиддаа хүргэж байна.

Энэхүү гарын авлага хувь хүний хийгээд улс орны хөгжлийн төлөөх үнэт зүйл, үнэт зүйлсийн чиг баримжааны талаар тодорхой ойлголт, санаа, сэдэл өгнө гэдэгт итгэлтэй байна.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР



**ҮНЭТ ЗҮЙЛ: ОЙЛГОЛТ,
ХАНДЛАГА**

М.МӨНХБОЛД

Удирдлагын Академийн
профессор, доктор

**АМЬДРАЛД СУРСАН,
СУРААГУЙН Л ЯЛГАА ГАРДАГ**



Ж.ГАЛБАДРАХ

"Шинэ Монгол" эрдмийн
хүрээлэнгийн ерөнхийлөгч,
Боловсрол судалын доктор



**ЭЕРЭГ ХАНДЛАГА,
ГОО ЗҮЙ**

Х.БАДАМГЭРЭЛ

"Андра Академи"-ийн
захирал, мисс, топ модель

**БОЛОМЖГҮЙ ГАЗАР
БОЛОМЖ БАЙДАГ**



Г.ГАНТУЯА

"Номадик контент"
үүсгэн байгуулагч



**БИД ИРЭЭДҮЙД ЯМАР
БАЙХ ЁСТОЙ ВЭ?**

Б.НАРАНЗУН

Нийгмийн ухаан, урлаг
судлаач, продюсер

**АМЖИЛТТАЙ
ОЮУТАН-ИРЭЭДҮЙН
МАНЛАЙЛАЛ**



Г.НЯМХҮҮ

"Эм Эн Маркетинг консалтинг" үүсгэн
байгуулагч






ҮНЭТ ЗҮЙЛ: ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА

Удирдлагын Академийн профессор, доктор

Сайн байцгаанаа уу? Залуучууд аа.

Энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр 2019 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр. Эдүгээгээс 2019 жил, түүнээс өмнө 500-600 жилийн тэртээ Грект Платон, Аристотель, Азид Лао-цы, Күнз Энэтхэгт Шагжамуни зэрэг хүн төрөлхтний агуу сэтгэгчдийн ярьж, хэлж үлдээсэн зүйл одоо ч үнэ цэнэ, утга санаагаа алдаагүй байдаг. Эх зохиолуудыг нь уншихад үнэхээр сонирхолтой гайхан биширмээр байдаг. Яагаад гэвэл тэртээ 2600 жилийн өмнө хэлсэн зүйл өнөөдөр утгаа алдаагүй байна. Тэдний үлгэрлэн зүйрлэж хэлсэн утга санаа улам бүр тодорч, бидний оюун ухаан, сэтгэлгээг тэлж байдаг нь сонин. Энэ 2600 гаруй жилд хүний хичнээн үе солигдсон билээ. Хүн бүр балчир, хүүхэд, залуу, хижээл, ахмад насыг туулж өнгөрүүлэхдээ өөрийн амьдралын туршлага, хорвоог таних арга ухаан, шийдвэр гаргах зарчим, үнэт зүйлтэй болсон байдаг.



Бидний амьдралын үнэт зүйл гэж юу вэ?

Үнэт зүйлийг ойлгох, амьдралд аливаа шийдвэрийг гаргах бидний хандлага юу вэ? Энэ талаар ярихыг хүсч байна. Ер нь үнэт зүйл, хандлага гэдэг юу вэ?

Өнөөдөр манай төрийн албан байгууллагуудын үүдэнд алсын хараа, үнэт зүйлсээ тодорхойлсон өгүүлбэрүүд бичигдсэн байдаг. Та нар ч гэсэн, үнэт зүйлийн тухай өөр өөрийн ойлголтой болсон байгаа.

Үг бүрийн утгад тодорхой ойлголт, ойлголт бүрийн цаанаа бодомж, бас сэтгэлгээ байдаг. Тийм бол үнэт зүйл, хандлага гэдгийг бид яж ойлгох вэ? Яаж зөв бодох вэ? Зөв сэтгэх ухаан гэж юу вэ? Сэтгэхүйн ямар хандлагыг би өөртөө шингээх ёстой юм бэ? Гээд олон асуулт гарна. Энэ асуултын хариу эртний грекийн гүн ухаантан Платоноос асууя гэж бодлоо. Чухам энэ санааг надад миний шавь Хамбингийн Пүрэвтогтох хэлсэн юм. Х.Пүрэвтогтох

маань “Багшаа, та үнэт зүйлийн тухай орчин үеийн ойлголт ярихаасаа илүү зүгээр л үлгэр яривал ясан юм бэ? Цэцэн мэргэнд дурласан философичид үгийн гүн утгын учрыг тайлдаг шүү дээ, та энэ тухай лекцээрээ яриач” гэсэн юм. Шавийнхаа санааг би дэмжсэн бөгөөд энэ үлгэр эртний грекийн гүн ухаантан Платоны “Төр ба улс” гэдэг эх зохиолд бий. Эх зохиол гэхээр ойлгох аргагүй том ном байна гэж бодох хэрэггүй. Учир нь эх зохиол уншина гэдэг өөр. Бидний сурах бичиг хичээл дээр уншдаг шиг тодорхой нэр томьёо, хууль зүйн үг хэллэгээр бичигдсэн байдаггүй. Зүгээр л хоёр хүн, багш шавьтайгаа ярилцсан асуулт, хариултууд байдаг. Гэтэл энэ энгийн мэт үг хэллэг асуулт, хариултыг ойлгоод дахин бодоход нэлээд хугацаа шаарддаг. Хүн бүр л өөрийнхөөрөө ойлгоно.

Платоны “Агуйн тухай ёт үлгэр”-ийг судлаачид, эрдэмтэд, философичид, гүн ухаантнууд бүгд өөр өөрийнхөөрөө ойлгож тайлбарласан байдаг. Учир нь, үлгэрийн ёт санаа, юмс үзэгдэл, тухайн хүний өөрийнх нь мэдлэг, ойлголтын хүрээнд үлддэг.

Яагаад “Агуйн тухай ёт үлгэр” гэж? 2500 жилийн тэртээх нийгмийг бод, төсөөл

дөө. Өнөөдөр ХХI зуунд, гар утас, интернет эрчимтэй хөгжсөн орчинд бид амьдарч байна. Гэтэл интернет нь үгүй-0, тийм-1, буюу 01 математик алгоритмаар зохиогдсон програм ажилласны үр дүнд бид гар утсаар ярьж, дэлхий даяар өөр хоорондоо гэрлийн хурдаар харьцаж байна. Ийм өндөр хурдтай цахим орчинд 25 магадгүй 30 жил өсөж торnisон та нарын итгэл үнэмшил, үзэл бодол, хүсэл мөрөөдөл, үнэт зүйл чинь өөр өөр. Ийм нийгмийн орчинд өссөн та нарын амьдралыг харах үзэл санаа бидний үеийнхнээс ч огт өөр байх. Гэтэл 2500 жилийн өмнө амьдарч байсан хүмүүсийн бодож сэтгэж байсан нь биднийхээс өөр гэж үү?

Би та нарт «Агуйн тухай ёт үлгэр»-ийг ярь.

Түнэр харанхуй агуйд эргэж харж чадахгүй, хөл толгой нь гинжлэгдсэн хүмүүс сууж байдаг. Тэдний эцэг өвгөд, үр ач нар энэ агуйд өссөн, магадгүй тэд энэ орчиндоо үхэх нь үнэн, төрөх нь үнэн. Тэд нэг л чигт харна, хүзүү, толгойгоо хөдөлгөн эргэж харж чадахгүй. Харин гинжлэгдсэн хүмүүсийн ард гол байх бөгөөд гол ба хүмүүсийн дунд

хүүхэлдэйгээр тоглосон жүжигчид байдаг. Тэд хүүхэлдэйн дүрсээр тоглож сүүдэр нь хананд тусан олон янзын хэлбэр дүрс, хөдөлгөөн бас дуу авиааг гаргана. Харин гинжлэгдсэн хүмүүс сүүдрийг харж, сонсож энэ бүхэн амьдрал гэж итгэж үнэмшин бодож байдаг.

Гэтэл яагаад ч юм нэг нь энэ гинжнээсээ салдаг. Гэвч тэр гар хөл нь суларчихаад байхад эргэж харж чаддаггүй. Арай хийж эргэж хараад анх удаа галыг харан, нүд нь гялбадаг. Тэр галыг хараад гайхна. Агуй дотор бүх л сүүдрийг амьдрал гэж ойлгож байсан тэр сүүдрийн дүрс хөдөлгөөнийг энэ гал харуулж байсныг ойлгож харамсдаг. Тэгтэл тэр агуин амсар дээр өөр нэг онцгой тусгал байгааг олж харна. Тусгалыг дагаж тэрээр агуйгаас гарна. Нарт ертөнцийн гэрэл түүний нүдийг нь сохлох шахдаг боловч энэ гэрэл түүнийг улам бүр гайхшуулна.

Яагаад гэвэл тэр од мичид, нар, сар, цэцэг навч, урьд нь хараагүй нарт ертөнцийн олон янзын өнгө, хэзээ ч сонсоогүй гайхамшигт дуу чимээ, шувуудын жиргээ зэрэг гоо сайхныг гайхан биширнэ. Агуйгаас өөр сайхан ертөнц байдаг юм шүү дээ гэж ойлгож баярласан ч бас маш их гэмшдэг. Учир нь агуй доторхи амьдрал нь аав, ээж, үр хүүхэд, наиз нөхөд нь

түүнээс өөр зүйлийг харж гинжлэгдсэн байгаа нь бодогдсон тул өөр үнэт зүйл байгааг хэлэхээр эргэж агуйд орно.

Тэр гэрэлтэй газраас түнэр харанхуй агуйдаа эргэж ороход нүд нь сохорсон ч харин ч илүү тод сайн “харж” төсөөлдөг болсон байв. Гинжлэгдсэн хүмүүс түүнийг шоолж, ярьж хэлж байгаад нь итгэж үнэмшээгүй юм.

Агуйд амьдрагсад түүнийг дээш гараад сохорсон, ухаанаа алдсан, өвчтэй гажиг хэмээн шоолцгоох болно. Тэр бүхнийг тэвчвэл Сократ лугаа болох бизээ хэмээн ётг үлгэр маань жаргадаг.

Платоны Агуин тухай ётг үлгэр товчхон нэг хуудсанд багтах бэсрэгхэн боловч маш олон санааг агуулсан. Санаа бүр нь ойлголт өгч ойлголт бүр нь оюун дүгнэлт хийлгэдэг.

Би ётг үлгэр дэх үгийн гүн утга, учрыг тайлбарлая. Та нар сайн тунгаа даа.

Агуй-Энэ үг орон зайд бөгөөд, газар нутаг магадгүй бидний төрж өссөн эх орон гэсэн утга санааг хэлнэ.

Гинж-Энэ үг хууль, дагаж мөрдөх дүрэм заавар, ёс заншил, салж чаддаггүй бидний

муу дадал, зуршил, магадгүй хувиа хичээсэн атгаг сэтгэл,


Хүүхэлдэйн жүжигчид-Тэд агуй дотор амьдарч буй хүмүүсээс илүү эрх чөлөөтэй, тэд гинжлэгдэгүй, бусдаасаа илүү амьдарч байгаа хэдий ч сэтгэлийн хувьд бас л агуй дотроо байгаа хоригдол. Тэд хүмүүсийг хуурч байгаагаа мэддэггүй бөгөөд өөрсдийнхөө үйлдлийг зөв гэж боддог. Ингэх нь тэдний амьдрал гэж ойлгодог хориглууд,

Сүүдэр янз бүрийн дүрс-Энэ үг хүүхэлдэйн жүжигчдийн зохиосон үзэгдэл, тэдний хүмүүст итгүүлж үнэмшүүлэхийг хүсч буй амьдрал юм.

Гал-Энэ үг шинэ санаа, шинэ технологи юм. НОКИА гар утсыг яаж хэрэглэх талаар 1910-аад онд ярьж байгаа хүүгийн талаар энэ лав солиорчихжээ гээд харамсаж байдаг талаар өгүүлсэн НОКИА-ийн сурталчилгаа байдгийг та нар санаж байгаа биз дээ.

Нар-энэ үг мэдлэг, боловсрол, хүч, өөрийн гэсэн итгэл үнэмшил, гэгээрлийг илтгэнэ.

Энэ зохиолын үгийн утга санааг тайлахыг хичээллээ. Одоо та бүхэн дахиад сайн тунгаа. Магадгүй ойлгомжгүй байж болно. Гэхдээ л



цаг хугацаа өнгөрөх тутам бид энэ үлгэрийн үргүүдийн гүн утгын учрыг ойлгох болно. Өндөр хөгжсөн улс орнууд иргэддээ багаас нь Агуин тухай ёт үлгэрийг ярьж, зохиолын утга санааг тайлбарлуулдаг. Тэд багад нь ёт үлгэр хэлбэрээр нийгмийн тухай ойлгуулж, мэдлэг нь тэлэх тутам илүү үнэт зүйл бий шүү, чи түүнийгээ олсон уу хэмээн багш нар нь асуудаг. Энэ утгаараа эртний Күнзийн сургаал, Будда Шагжамуни, Аристотель, Платоны сургаал эх зохиолуудын үнэ цэнэ агуу юм.

Залуус та бүхэн эх зохиолуудыг уншихдаа үгийн утгыг л ойлго, ойлголт дээрээ тулгуурлан энэ нийгмийн үзэгдлийг тайлбарлахыг хичээ.

Тэгвэл агууд байгаа хүн шиг сайн сайхан зүйлийг олж харж гэгээрдэг. Агуун тухай ёт үлгэрт гарч байгаа харанхуй нь бидний амьдрал, манай нийгэм юм. Харин гэрэл гэгээ нь бидний мэдлэг, боловсрол ухаарал юм. Бид өөрсдийгээ илүү боловсруулж илүү мэдлэгтэй, хүчтэй л болохгүй бол, бид муу дадал зуршил буруу дүрэм заавраас салахгүй бол яг л агууд байгаа гинжлэгдсэн хүмүүс мэт болно. Хоосон дүрсний сүүдрийг харуулах бидний төлөө байгаа мэт хүүхэлдэйн жүжигчид шиг хүмүүсийг бид таньж сурх хэрэгтэй. Харанхуйд байгаагаа гэрэлтэй гэж ойлгодог, харанхуйд байгаа галыг одоохондоо унтрааж, бас асааж ч болно, жүжгийн үзэгдлийг өөрчилж болно.

Бидний ХХI зууны хүч чадал юунд оршиж байна вэ? Бид өнөөдөр цахим, даяарчлагдсан ертөнцөд амьдарч, өөрсдийн үзэл бодол, саналаа чөлөөтэй илэрхийлж чадаж байна. Цахим мэдээллийн ертөнц бидний сонголтод шууд нөлөөлж, бид энд нийгэм, эдийн засгaa удирдаж чадах бололцоог өгч байна. Би энд цахим засаглалын тухай өөрөөр хэлбэл, цахим засаглал гэж иргэдийн засаглалын тухай ярьж байгаа юм. Платоны шавь Аристотель төлөөллийн ардчилал тийм сайн

ардчилал гэж үү? Хамгийн муу ардчилал юм биш үү гэж хонийг төлөөлөөд чоно яриад байгаа юм бишүү гэж ёт үлгэрээр хэлсэн байдаг. Магадгүй өнөөдөр хамгийн чухал үнэт зүйл маань үнэн зөв мэдээлэлтэй байх, мэдээллийг зөв боловсруулж чадах, мэдээлэл маань бидний хүсэл бодлыг илэрхийлэгч байх гээд олон зүйлийг хийх шаардлага байна. Магадгүй бид төлөөллийн ардчиллын өөр хэлбэр рүү орж, 10, 20 жилийн дараа гар утаснаасаа шууд саналаа өгч сонгох эрин үед очих байх.

Ингээд дүгнэцгээе, бүгдээрээ.


Унэт зүйл гэж чухам юу юм бэ?
Унэт зүйл гэдэг бол мэдлэг, боловсрол юм. Мэдлэг боловсролтой байхын хэрээр илүү ёс зүйтэй, ёс суртахуунтай болдог. Илүү ойлгож мэдэж туршлагажихын хэрээр бусдыг болон өөрийгөө хундэлдэг. Бидний аливаа шийдвэр гаргах зарчим, хандлага ч үүнийгээ дагаад өөрчлөгдөнө.



Платон "Гал хэмээгч нь гэрэл гэгээ юм. Гэрэл гэгээ гэдэг нь нар юм. Мэдлэг боловсрол, хүч нь үнэт зүйл юм" гэж ёпт үлгэрээ дуусгасан байдаг.

Одоо та нар бод доо. Бид өнөөдрийн нийгэмд агуй дотор байгаа хүмүүс шиг байна уу? Хүүхэлдэйн жуужигт тоглогч нь хэн байна вэ? Энэ нийгэм маань бидний хүсч буй амьдралыг бүтээж байна уу, эсхүл зүгээр хоосон зүйл ярьсаар байна уу? Өнөөдөр бид илүү их харанхуйг хараад байна уу? Өнөөдөр бид гэрэл гэгээ, гоо сайхан ертөнцийг харж чадаж байна уу? Бид юуг илүү хүсэж байна вэ? Энэ бүх асуултад хариулахын тулд бидэнд илүү их мэдлэг, эрч хүч, боловсрол гэгээрэл хэрэгтэй юм.

*Анхаарал хандуулсан та бүхэнд
баярлалаа.*





ЭРЭГ ХАНДЛАГА, ГОО ЗҮЙ

“Андра Академи”-ийн захирал,
мисс, топ модель

Сайн байцгаана уу? Бүгдэд нь энэ өдрийн мэнд хургэе. Намайг Хүрэлбаатарын Бадамгэрэл гэдэг. Залуу хүний хувьд та бүгдтэй уулзах боломж олдсон учраас өнөөдрийн урилгыг маш таатай хүлээн авсан. Эерэг хандлага гоо зүйтэй хэрхэн уялдаа, хамаарлтай байдаг, хандлагын үр дүн өөрийн минь амьдралыг хэрхэн өөрчилснийг та бүхэнтэй хуваалцья.

Хандлага гэдэг бол нэг өгүүлбэрээр таны бусдад төрүүлэх сэтгэгдлийг үнэлэх үнэлэлт юм. Та хаана, хэзээ, хэрхэн бие авч явах, бусадтай яаж харилцах нь хүмүүс таныг үнэлэх үнэлэлт болдог. Миний судалж ойлгосноор хандлагыг гоо зүйтэй уялдуулан дараах З чиглэлээр шинжикж тодорхойлж болно.

Зөв харилцаа

Зөв биеийн хэлэмж

Гадаад төрх байдал /зөв имиж бүрдүүлэлт/

Эдгээр З зүйл нийлж та бүхнийг зэрэг хандлагатай хүн болоход тусалдаг. Та зөвхөн хүнтэй зөв, таатай харьцдаг байгаад буруу хувцасласан, эсхүл биеийн хэлэмж буруу бол таны хандлагын илэрхийлэл дутуу болдог.

Зөв харилцаа ба анхны сэтгэгдлийг 2 удаа төрүүлэх боломжгүй

АНУ-д 70 жилийн турш тодорхой хэсэг хүний амьдралын үйл явц, өөрчлөлтийг судалсан судлаачид зөв харилцаа бол тогтвортой гэр бүл, таатай орчин бүрдүүлэх хамгийн чухал зүйл гэдэгт санал нэгдсэн байна. Зөв, таатай харилцаа нь сэтгэл өөдрөг, таатай амьдрах, урт наслах нөхцөлийг бүрдүүлдэг байна. Харилцаа гэдгийг маш чухалд тооцон авч үзэх хэрэгтэй. Та бусадтай харилцах харилцаагаа яаж эхлэхээс амжилттай, эсхүл амжилтгүй байх нь шалтгаална. Анхны сэтгэгдлийг 2 удаа төрүүлэхгүй шүү дээ. Тиймээс харилцааг зөв эхлүүлэхдээ инээмсэглэл болон зөв мэндчилгээнээс эхлүүлээрэй. Энэ тухай дараагийн хэсэгт дэлгэрүүлж тайлбарлах болно.

Биеийн зөв хэлэмж гэж юу вэ?

Хүнтэй харилцаж байхдаа биеийн буруу хэлэмж, илэрхийллээс болж тухайн хүнд дутуу, эсхүл буруу дүгнэгдэж үр дүнгүй нөхцөл байдал үүсгэдэг. Жишээ нь, хүнтэй харилцахдаа гараа элгэндээ тэврэх үйлдэл хийх бол таагүй, тавгүй байгаа, аливаа зүйлийг хүлээж авах хүсэлгүй, эсхүл ааш муутай байгааг илтгэх биеийн хэлэмж юм. Дараагийн бас нэг нийтлэг буруу хэлэмж

бол магадгүй, та нар шалгалт, шүүлэг өгөхдөө тогтвортой, бат зогсож чадахгүй, биеэ хөдөлгөх, займчих, нүдээ эргэлдүүлж байвал энэ нь багшид та өөртөө итгэлгүй, хариултыг мэдэхгүй байна гэсэн анхны сэтгэгдэл төрүүлнэ. Үр дүн мэдээж таны хүссэнээс эсрэгээрээ гарах тохиолдол олон. Энэ мэтчилэн биеийн хэлэмжээс шалтгаалан та бусдад буруугаар дүгнэгдэх, ойлгогдох эрсдэлтэй байдаг учир нүүр, харц, бие болоод гарын хөдөлгөөнөө анхаарч байгаарай. Биеэ хэрхэн авч явах, биеийн ямар хэлэмж үзүүлж буйгаас шалтгаалан таныг хүмүүс тодорхой түвшинд хүндэлж, үнэлэх боломжтой.

Чиний имиж чамайг илэрхийлнэ Гадаад төрх байдал /имиж бүрдүүлэлт/

Яаж хувцаслаж байгаа тань таныг тухайн үйл ажиллагаа, аливаа арга хэмжээнд хэр ач холбогдол өгсөн, хэр мэдрэмжтэйг илтгэнэ. Та чухал арга хэмжээ юм уу, чухал гэж бодож байгаа үйл ажиллагаан дээр зөв хувцаслах нь таны заавал сахих ёстой дүрмүүдийн нэг. Хувцаслалт бол хүндлэлийн бас нэг илэрхийлэл юм. Харилцаа, биеийн хэлэмж, гадаад төрх эдгээр нь таны бусдад нөлөөлөх буюу үнэлэгдэх, хүндлэгдэх боломжийг илүү

тэлж өгдөг. Эдгээр гурван зүйлийг судлаад эзэмшсэн байхад хаана ч явсан таныг таны хүссэн хэмжээнд дүгнэх, хүссэнээрээ таатайгаар ойлгогдоход ихэд тус нэмэр болох болно.

Боловсролоос хүчтэй хандлага руу хошуурахын учир

Өндөр мэдлэг боловсрол үнэндээ юуг ч өөрчилдэггүй,
Харин хандлага бүхнийг өөрчилдөг.
Абраам Линкольн. АНУ-ын 16 дахь ерөнхийлөгч

Дэлхийг өөрчилсөн хүмүүст аливаа нийгмийн тулгамдсан асуудлуудыг өөрчилж чадна гэсэн мятаршгүй эерэг тэмүүлэл, маш том зорилго, болно, чадна гэсэн зөв, эерэг хандлагаас ихээхэн шалтгаалсан байдаг. Эерэг хандлага жижиг өөрчлөлтүүдээс эхэлдэг.

Хэрхэн эерэг хандлагыг өөртөө суулгах вэ?
Мэндчилэх
Нүдтэй харилцах
Сонсох
Биеийн хэлэмжээ удирдах

Мэндчилэх

Монголчууд мэндлэх, хүндлэх арвин их баялаг уламжлалтай. Та сайн байна уу? Та амар амгалан байна уу? Сайхан зусч байна уу? Таны лагшин тунгалаг уу? Сонин сайхан юу

байна? гэх мэт мэндчилгээний олон төрөл бий. Гэтэл манай залуучууд мэндлэхдээ ихэвчлэн Ні, Юу байна? гэхчлэн, богиносгосон буюу гадаад үгийг ашиглаж байна. Гэтэл эдгээр нь бүрэн зөв мэндчилгээ болдоггүй. Өөрөөр хэлбэл, эдгээр дутуу дулимаг мэндчилгээ нь дулимаг шигээ өнгөц мэдрэмжийг төрүүлдэг байна. Түүнчлэн мэндлэхдээ анхаарах дараагийн зүйл бол инээмсэглэл юм. Инээмсэглэл нь бусдад үнэ төлбөргүй өгч болох хамгийн үнэ цэнэтэй бэлэг. Гудамжаар зөрсөн нэгэн инээмсэглэлээ гэхэд танд таатай сэтгэгдэл төрөх, энерги сэргэх боломжтой болдог. Гадны улс оронд хэн нэгэнтэй харц тулгарахад заавал инээмсэглээд мэндэлдэг, харин Монголчууд ихэнхдээ аль болох харцаа буруулахыг хичээдэг. Эдгээр хандлагыг бүгдээрээ хамтдаа өөрчилцгөө. Хүнтэй инээмсэглээд сайхан мэндчилдэг больё.

Нүдтэй харьцах

Хүний нүд рүү харж ярьж сурх нь харилцааг маш амжилттай болгодог. Бид хүнтэй харьцахдаа нүд рүү нь хардаггүй учраас тухайн хүн таныг тогтвортой сонсдоггүй, сонсох хүсэлгүй болдог. Хүнтэй харьцахдаа зөв цэх зогсож мэндчилээд нүд рүү нь харж хэлэх үгээ хэлбэл нухацтай хүлээж авна.

Нүдтэй харьцахтай уялдаа холбоотой зүйл бол дуу хоолойн өнгө. Хоолойн өнгөөр хүний сандрал, тавгүй байдал шууд илрэдэг. Үг, үсгийг дуудах аялга ч мөн чухал.

Сонсож

Хүмүүс сонсож чаддаггүй хүнтэй таатай яриа өрнүүлж чаддаггүй. Бид бусдыг сонсож сурх ёстой. Сайн сонсогч байж чадвал хүндэтгэлийг бий болгодог буюу бусад хүмүүс таныг хүлээн зөвшөөрч, таныг ч мөн сонсох сэдэл төрүүлнэ гэсэн үг. Сонсож сурна гэдэг бол маш том соёл юм шүү.

Тэвчээртэй байх тийм ч хэцүү биш

Бид амьдралын явцад янз бүрийн зан ааш, харилцаатай хүмүүстэй тааралддаг. Хүлээнтэй байж, аливааг яаран дүгнэж, шүүмжлэлгүйгээр ул суурьтай бодолтой байж, бусдын шалтгаан таныхаас хэд дахин асуудалтай, сэтгэл өвтгөмөөр байж болохыг үргэлж санаж байгаарай. Тухайн хүн ямар ч нөхцөлд, ямар ч асуудалтай байж болно. Бусдын асуудал, үнэн бодит шалтгааныг мэдээгүй байж таны гаргасан таагүй харьцаа, хандлага магадгүй хэн нэгний өдрийг утгагүй болгож, арай гэж алхаж буй тэнхээг нь сорж, сүйрүүлж мэднэ.

Бусдыг шүүмжлэх шаардлага үнэхээр гарах бол та эхлээд таатай зүйлийг нь дурдаж, дараа нь болохгүй байгаа зүйлийг нь хэлж болно. Дэйл Карнеги “Бусдыг шүүмжлэхээс илүү та өөртөө илүү анхаарч, өөртөө төвлөрөх цаг болсон” гэж зөвлөсөн байхад, Бурхан багш “Бид бүхэл амьдралынхаа турш бусдад санаа зовж амьдардаг, бусдын юм болгоныг л ярьдаг, шүүдэг, өөрийгөө өнгийж харах нь уг нь илүү чухал” гэж айлдсан нь бий.

Бусдад анхаарч, бусдыг шүүмжлэхийн оронд өнөөдөр би хэнд ямар сайн зүйл бүтээхэд нь туслав, хэнд таатай сэтгэгдэл төрүүлж, инээмсэглэл бэлэглэв, хэнд урмын сайхан үг хэлэв гэдгээ тунгааж байгаарай. Бид хэрхэн өөртөө зөв хандлага суулгах талаар хоорондоо уялдсан 4 зүйлийн талаар ярилаа. Дээрх 4 зүйлийг өөр дээрээ хэрэгжүүлээд үзээрэй. Та бүхэнд өөрчлөлт гарна гэдэгт би итгэлтэй байна.

Зөв хандлага юу авчирдаг вэ?

Мэдээж, хамгийн түрүүнд таатай харилцаа, тухайн хүнд таатай сэтгэгдэл төрүүлэх буюу сайнаар хоногшиход тусална. Зорилгыг илүү томруулна, өөдрөг үзлийг суулгана, боломжийг

тэлж өгдөг. Хандлага ямар байхаас шалтгаалан таны мөрөөдөл биелэх, биелэхгүй нь тодорхойлогдоно. Хэрвээ та би чадна, биелнэ гэсэн өөдрөг сэтгэхүйтэй хандвал аливаа зүйл бутнэ. Энийг чадахгүй гэж бодвол таны зөв, та чадахгүй. Ердөө л ийм байдаг.

Би өөрийнхөө амьдралын 3 үе мөчлөгийг ярья. Энэ үеүдэд миний амьдралд маш том өөрчлөлтүүд гарсан байдаг. Өөрөөр хэлбэл, хандлага өөрчлөгдэж, өөрийгөө өөрчлөх ёстой юм байна гэсэн мэдрэмжийг, ойлголтыг тэндээс олж авсан юм. Үүнийгээ та нартай хуваалцъя.

Тэвчээрт сургаж, өөдрөг узэл руу хөтөлсөн 13 настай минь

Намайг 13 настай байхад ээж минь хүнд өвдсөн юм. Ээжийгээ тэнхрүүлэх, шинэ хонины махтай шөл хийж өгөх, эмнэлэг явахдаа хэн нэгнээс автобусны мөнгө гүйхгүй байхыг хичээж байлаа, тэр үед. Нэг удаа тэмцээнд орж тэнцээд мөнгөн урамшуулал авч, түүгээрээ ээждээ шөл хийж өгөх гэж хонины мах авч билээ. Шөл хийчихээд ээж рүүгээ алхаж байсан амьдралын минь тэр хэсэг надад бас тодорхой хэмжээний юманд няцаж,

ухарч болохгүй гэсэн ойлголтыг хамгийн түрүүлж бяцхан оюунд минь суулгасан гэж боддог. Ээж минь “Охиныхоо хийж өгдөг байсан шөлийг уугаад, хүүхдүүдийнхээ хичээл зүтгэл, халамж хайраар хуч хийж, эрүүл болж, эргээд хөл дээрээ бослоо” гэж ярьдаг. Ээжийн минь өөдрөг үзэл, үр хүүхдээ гэсэн хайр нь боломжгүй гэж яригдаж байсан бүхнийг үгүйсгэж чадсан. Өөдрөг зүйлд ямар их хүч чадал оршдогийг би тэгэхэд мэдсэн. Ээжээсээ би өөдрөг үзэлд суралцаж, ээжид минь болон бидэнд ирсэн тэр хэсэг хугацааны бэрхшээл саадаас хатуужил тэвчээрт суралцсан гэж боддог. Эргээд дурсахад тэгсэн ч байдаг. Эрүүл болохын төлөө тэмцэж буй ээжийгээ харсан би, дүү нар минь мятрашгүй зүтгэл, буцашгүй зорилго, шантаршгүй өөдрөг хандлагаар цэнэглэгдэж байсан, тэр үед. Бидэнд их зүйлийг ойлгуулж, биднийг өдий зэрэгт хүргэсэн ээждээ талархан залбирдаг. Ээжийгээ эргэж очих бүртээ бидний баатар, хэнээр ч орлуулшгүй хүн гэдгийг нь хэлж, илэрхийлж, ядаж үгээр эмчлэхийг хичээж байсан бидэнд ээж минь жилийн дараа эрүүл болж ирсэн. Энэ өдрөөс хойш өглөө бүр би өөртөө “Бадамгэрэл ээ өнөөдөр чи хэн нэгнийг заавал баярлуулах

урмын сайхан үгийг хэлж, бусдын амьдралд үгээрээ, үлгэр дуурайллаараа өөрчлөлт хийх өдөр шүү” гэж хэлдэг. Хүмүүстэй харьцаж байхдаа тухайн хүнийг үгээрээ баярлуулахыг, дутагдаж буй үгийг нь хэлэхийг хүсдэг. Хүссэнийхээ хэрээрээ тэгж сурсан юм. Хүнд үнэ цэнэтэй зүйл бэлэглээ гэж бодож байгаа бол энэ нь ердөө урам, дэмжлэгийн үг л байдаг.

Ярих ур чадварт “ургуу татсан” 20 нас минь

2010 онд “Монгол омогшил” нэртэй улсын хэмжээний илтгэлийн уралдааныг UBS телевиз, “Нийгмийн Ардчилал” Монголын Оюутны холбоо хамтран зохион байгуулсан юм. Илтгэлийн уралдаанд хот, хөдөөгийн 500 гаруй залуучууд өрсөлдсөн. Тоон дотор үсэг болж мисс болсон Бадамгэрэл миний бие оролцсон нь өөрийгөө өөр шатанд аваачихыг хүссэн, шинийг эрэлхийлэх оролдлого байв. 500 залуугаас шилдэг 50 илтгэгчийн тоонд багтаж, сайхан нөхөдтэй болж, өөрийгөө хөгжүүлж, чадах зүйлээ ойлгосон нас минь байсан юм. Финалын 30 илтгэгчийн нэг болж чадаагүй ч өөрийгөө өөр өнцгөөс нээж чадсан. Заримынх нь нүдэнд би хэлбэр талаасаа ялагдсан мэт боловч үнэндээ ялсан


мэдрэмж авсан. Боломж хэнд ч, хаана ч тэгш байдгийг ойлгож, тэр өдрөөс хойш боломжийг ашигладаг, боломжийг бүтээдэг хүн болохыг зорьж эхэлсэн. Үүний үндсэн дээр бүх насхыханд зориулсан хувь хүний хөгжил, гоо зүйн мэдлэгийг ахисан түвшинд хөгжүүлэх, тэднийг урамшуулж зорилго, мөрөөдлийнхөө төлөө тэмцдэг, хүчирхэг, соёлтой, ухамсартай, эрэг, зөв монгол хүн бэлтгэх мөрөөдөлдөө автаж, зорьж эхэлсэн юм.

Амжилтас атгасан 23 нас минь

23 настайдаа би ээж болсон. Миний хүүг Ананд гэдэг. Одoo 6 настай. 5 сартай жирэмсэн байхад хайрт найз Энхтуяатайгаа хамт “Андра” загварын агентлагийнхаа үйл ажиллагааг эхлүүлж байлаа. Энхтуяа минь бас 7 сартай жирэмсэн. Энэ үед загварын агентлаг нээх гээд явж байхад биднийг олон хүн чадахгүй, боломжгүй зүйл эхлүүлжээ гэж байсан. Том гэдэстэй, жирэмсэн 2 хүүхэн өндөр өсгийт дээр алхаж, гоё сайхан, гоолиг байхыг заана гэхээр тэр бүр хүмүүсийн санаанд буухгүй байсан юм шиг байна лээ. Гэсэн ч хүүхэд наснаас минь эхлэлтэй алдаа оноо, уналт босолт надад яг сургалт, сургууль шиг байсан, сэтгэл зүйн хувьд ч гэсэн хүчирхэг болсон байлаа. Мэдээж бид

хоёр чадсан. Анхны элсэлт маань З суралцагчтай байсан бол өдгөө 1000-аад суралцагчийг бэлтгэж, авьяасыг нь хөгжүүлж, илүү өөртөө итгэлтэй зорилготой, зөв монгол хүн болоход нь их бага хэмжээгээр нөлөөлсөн байна. Одоо “Андра академи”-ийнхаа ирээдүйг илүү том, хүчтэйгээр дэлхийн хэмжээнд харах болжээ.

Амьдралын минь энэ З мөчлөг миний хандлагыг эрс өөрчилсөн. Илүү том зорилгыг биелүүлэхийн тулд өмнөх зорилгодоо хүрчихээд үргэлжлүүлэн илүү өргөн хүрээтэй харж, мөрөөдөж, хөдөлмөрлөх ёстойг ойлгуулсан. Мөрөөдөлдөө шунан дурла залуус аа, заавал амжилт, аз жаргал авчирдаг юм. Эцэст нь хэлэхэд Та бол дахин давтагдашгүй цор ганц. Та бол З сая хүний нэг гэж амьдрахаас илүү та 7 тэрбум гишүүнтэй дэлхий гэдэг гэр бүлийн 1 чухал гишүүн нь гэж өөрийгөө бодоорой. Томоор сэтгэж, үргэлж эерэг, зөв байж, хайрлаж, аливааг илүү өргөнөөр харж, өөдрөг мятаршгүй тэмүүлэлтэй, үргэлж сурч, хөгжиж амьдрахыг уриалья. Танд бүтээж чадахгүй зорилго, хүрч чадахгүй оргил гэж байдаггүй юм шүү. Амжилт хүсье.





БИД НАР ИРЭЭДҮЙД
ЯМАР БАЙХ ЁСТОЙ ВЭ?

Бүгдээрээ өнөөдөр мөрөөдлийн тухай ярьцгаая. Эхлээд бүгд гар утасныхаа камерийг асаагаад, над руу чиглүүл дээ.

За, одоо та бүхэн миний зургийг утсаараа аваад утсандаа хадгалаарай.

-Баярлалаа.

Хүнд хамгийн анх төрүүлэх сэтгэгдэл маш чухал байдаг. Анх яаж харагдана, амьдралынхаа туршид тэр дүрээрээ л хадгалаагддаг.

Тиймээс анхны сэтгэгдлийг зөв төрүүлэх нь маш чухал. Би та нарын утсанд зургаа үлдээсэн. Энэ мөчөөс хойш миний зураг өнгөрсөн рүү явж байна. Тиймээс бидний ирээдүй ямар байх талаар ярилцъя.

Юуны түрүүнд өөрийнхөө тулсан амьдрал, амьдралын туршлагаас жишээ хуваалцъя. Та бүхэнд өөрт тохиолдсон нэгэн түүхийг ярьж өгье. 2010 онд би хүнд өвчин тусч, Сингапур улсын эмнэлэгт хагалгаанд орохоор хүлээж байсан ѿ. Миний хажууд арван өвчтөн байсан

бөгөөд бүгд сэтгэлийн хямралтай, нүдний цог нь бөхсөн, үс нь халцарсан, ирээдүй нь бүрхэг хүмүүс сууцгааж байлаа. Тэр үед би, гурван сарын дараа энэ хорвоогоос явах гээд байдаг, амьдрал яагаад надад ийм шударга бус хандаж байна вэ, би хэнд муу зүйл хийлээ гээд олон зүйлийг бодож байсан. Ирээдүйгүй байх ямар аймшигтайг тэр үед эргэцүүлж, мэдэрч байв. Та нар ирээдүйгүй байх ямар болохыг төсөөлөөд үз дээ.

Тэгсэн удалгүй утас дуугарч "Хар сарнай" хамтлагийн дуучин С.Амараа залгаж байна.

Амараа:

- Би хэний хүүхэд билээ? гэж байна.

Би:

- С.Сүхбаатарын /Төрийн соёрхолт, бүжиг дэглээч/

Амараа:

- Миний найз чи хэний хүүхэд билээ?

Би:

- Бадрууган /МУУГЗ, кино найруулагч/

Амараа:

- Миний өвөө хэн билээ?

Би:

- Ц.Сэвжид/МУАЖ, Төрийн соёрхолт, бүжиг дэглээч/

Амараа:

- Чиний өвөө хэн билээ?

Би:

- Ж.Бадраа /МУУГЗ, хөгжмийн зохиолч/

Амараа:

- Чи бид хоёр ямар үндэстэн билээ?

Би:

- Монгол.

Амараа:

- Тийм ээ, өшөө чанга.

Би:

- Тийм ээ, тийм.

Яг ингэж хэлээд, миний цээж задраад дотроос муухай зүйл гараад явчих шиг болсон. Түүний дараа би, надад үлдсэн гурван сарын хугацаанд яаж сайхан амьдарч болох талаар л бодож эхэллээ. Гомдоосон хүмүүсээсээ училалт гүйя, хийж чадаагүй зүйлээ хийе, идэж үзээгүй хоолоо идье гэж бодож байлаа. Гурван сар л болохоос 30 жил амьдрах байсан ч зарчмын хувьд нэг л зүйл рүү явж байгаа шүү дээ. Гурван сар бол хүний амьдралд маш их зүйлийг өөрчлөх, өөртөө итгэлтэй байх,

өөрийгөө ариусгах, өөрийгөө хүмүүст захиж үлдээх хангалттай цаг хугацаа юм билээ.

Ирээдүй бэлэглэсэн итгэмзээргүй боломж

Миний хагалгаа амжилттай болсон. Эмч хэлэхдээ, та маш их азтай хүн юм, хорт хавдар нь дотроо хагараагүй байна, харин гаргаж ирэхэд шууд л хагарсан гэсэн юм. Нэг л өдөр өнгөрсөн бол магадгүй би энд зогсохгүй байсан. Тухайн үед миний өөртөө итгэсэн итгэл, өөрт байгаа зүйлдээ сэтгэл хангалуун байж чадсан нь, бурууг бусдаас биш өөрөөсөө хайх, бусдыг гэх тэр хандлага, мөн тэнгэрээс өвөг дээдэс минь ивээж, надад дахин амьдрах боломжийг олгосон гэж боддог.

Тэр цагаас хойш би ирээдүйн талаар маш их боддог болсон. Ирээдүй гэж юу вэ? Ямар байх бол? Ирээдүйд бид хаана байх бол? Бага байхдаа уншсан зөгнөлт зохиол дээр гардаг шиг байх болов уу гэх мэт. Тэгвэл хүн бүр өөрийн ирээдүйтэй байдаг. Өнөөдөр та бүхэн ч гэсэн өөрийнхөө ирээдүйн төлөө санаа зовж буй учраас энд цугларсан байх. Өнөөдөр бидний хийж байгаа зөв зүйл сайхан ирээдүй, сайхан дурсамжийг авчраас та бид одоо

цагийг өөрийн ирээдүйн төлөө анхаарах, ашиглах, хичээх ёстай.

Би оюун санаа, бодлоороо цаг хугацаагаар аялах дуртай. Би дунд үеийн төлөөлөл. Дээд үед миний ах нар бий. Доод үед та нар минь байна. Хэдийгээр бид бүгд нэг цаг хугацаанд, нэг хэлээр ярьж, нэг улсад амьдарч байгаа ч тулсан, сурсан, итгэсэн зүйлсээрээ ялгарч, өөр өөрийн ертөнцөд тус тусдаа амьдардаг. Заримдаа бие биеэ ойлгохгүй үе ч бий. Миний хувьд аль аль үеийг нь мэддэг, бас харьцаж харилцаж чаддаг болохоор өөрийгөө бас нэг талаасаа цаг хугацаагаар аялагч гэж боддог.

Өөртөө найд, чамайг өөрчлөх хүч чамд байгаа

Хөгжил бол ирээдүйг үргэлж тодорхойлж байдаг. Одоогоос 15 жилийн өмнө бид 1GB-ын багтаамжтай флеш дискийг хараад дэлхий ертөнц ямар хөгжсөнийг гайхаж байсан. Гэтэл өнөөдөр 1TB-ын багтаамжтай болсон байна. Хөгжил нь улам хурдалсаар тун удахгүй гэрлийн хурд руу шилжих байх. Тиймээс ирээдүйд залуучууд та бүхэн тэр хурд, хөгжил дээр ажиллах оюуны чадавхтай байх ёстай болно. Чиний ирээдүй, нийгмийн

хөгжил, цаг хугацаа ингэж шаардаад байгаа юм. Ийм учраас та бүхэн ирээдүй рүү явахын тулд маш их боловсorch, биеэ даах чадвартай байх хэрэгтэй болоод байна. Сургууль та нарт өрөнхий суурь мэдлэгийг олгож, хамт олонтой болгож, нийгэмшүүлж буй процесс болохоос биш та бүгдийг төгс мэдлэгтэй хүн болгож буй хэрэг биш. Тэгэхээр сургууль, багшид 100 хувь найдах биш, өөртөө л итгэж найдах болж байгаа биз.


Дэлхий дээр сурх шаардлагагүй 10 мэргэжлийн жагсаалтыг судалгаагаар гаргасан байсан. Энэ нь юутай холбоотой байна гэхээр мэдээлэлд ойр, хүрэх бололцоо нээлттэй болсон. Зарим мэргэжлээр заавал сургуульд сурх шаардлагагүй. Жишээ нь, жүжигчин болоход хамгийн чухал нь авьяас. Чи авьяастай бол заавал танхимаар суралцах биш, жүжигчний мэдлэгийг дэлхийн маш олон мэдээллийн сангаас хэлтэй бол өөрөө олоод сурх боломжтой болсон байна. Энэ нь хувь хүний хөгжил ямар чухал болсныг харуулж байна.

За, одоо ирээдүйгээ мөрөөдөж төсөөльье. Жишээлбэл, би өнөөдөр өвдлөө гэхэд дүүргийн эмнэлэгт очиж баахан дараалалд зогсон цаг

хугацаа алддаг. Тэгвэл ирээдүйд бид өөрсдийн өвчний оношийг гар утас руугаа зүгээр л үлээж ДНК мэдээлэл оруулснаар өөрийн бүтэн оношийг эмчилгээ болон уух эмиин жортой авах боломжтой болно. Ирээдүйд үйлдвэрлэлд маш их өөрчлөлт явагдана. Механик үйлдэл хийдэг ажилчид яваандаа шаардлагагүй болж техник, компьютерийн хийж чаддаггүй ажлыг хийх чадвартай хүмүүс л үлдэнэ. Компьютер, хиймэл оюун ухаанаас хүн юугаараа ялгагдах вэ? Бие организм, сэтгэл болон сүнсээрээ ялгардаг. Бусдаар биднийг орлох бололцоотой. Иймээс бид авьяас билиг, бүтээлч чадвараа хөгжүүлэх шаардлагатай. Авьяас гэхээр заавал урлагийн биш, хүний өөрийн төрөлхийн чадварыг хөгжүүлэх тухай юм. Иймээс өөрийн авьяасаа илрүүлж, хөгжүүлснээр тэр нь таны давуу тал болно.

Хайр бол ирээдүйн эрчим хүч гэж би боддог. Хайр бол энэ дэлхийн хамгийн хүчтэй зүйл. Бид бие биеенээ ургэлж хайрлаж, тэр эрчим хүчийг тэтгэж байх ёстой. Хүн хүнээ хайрлаж сурах хэрэгтэй. Тиймээс энд эх хүн маш чухал үүрэгтэй юм. Охиддоо захиж хэлэхэд хүний төлөвшлийг эх хүн тавьдаг учир уг, хэл, үйлдээ сайн хянах хэрэгтэй. Ирээдүйн хүчтэй иргэн та нараас их шалтгаална.

Бидний хамгийн чухал хөрөнгө оруулалт бол үр хүүхэд, гэр бүл юм. Би үгүй боллоо гэхэд үр хүүхэд минь үлдэх учир сайхан нийгмийг үлдэх ёстой. Бидний үр хүүхдүүд тэр гэрлийн хурдтай зэрэгцэн амьдарч чадна гэдэгт итгэж байна. Цаг хугацааг хүн хэзээ ч алгасаж болдоггүй. Хүн цаг үетэйгээ зэрэгцэн амьдардаг гэдгийг л санаж яваарай.





АМЬДРАЛД СУРСАН, СУРААГҮЙН Л ЯЛГАА ГАРДАГ

“Шинэ Монгол” эрдмийн хүрээлэнгийн

Эхлээд өөрийгөө танилцуулъя. Намайг Ж.Галбадрах гэдэг. Би дөнгөж 56 настай. Ингэж хэлэх нь надад эрч хүч өгдөг юм.

1981 онд 53-р сургууль төгссөн.

1981-1986 онд МУИС-ын физикийн анги, бакалавр

1997-1999 онд Япон, Ямагата их сургууль, боловсрол судлалын магистр

1999-2002 онд Япон, Тохоку их сургууль, боловсрол судлалын докторант

2016 онд МУБИС, боловсрол судлалын доктор, (Ph.D)

Ажлын туршлага:

1986 онд Төв аймгийн 1-р 10 жилд багш
1986-1990 онд ХААДС-д физикийн багш
1990-1992 онд Боловсролын хүрээлэнд судлаач

1992-1995 онд Нийслэлийн 84-р сургуульд дэд захирал

1995 онд мэргэжил дээшлүүлэхээр Японыг зорив.

2000 онд “Шинэ Монгол” сургуулиа байгуулж, захирал болов.

Би боловсролын бүх салбарт ажиллаж үзсэн туршлагатай.

Японы хамгийн том мөнгөн дэвсгэрт дээр байдаг соён гэгээрүүлэгч Фукузава Юкичи нь “Суралцахуйг эрхэм болгох” гэдэг ном бичсэн бөгөөд “Кэйо Гижюку” хэмээх сургуулийн үүсгэн байгуулагч юм. Фукузава Юкичи “Хүнд сурсан, сураагүйн ялгаа л гардаг” гэсэн алдартай үгээ хэлсэн байдаг. Өнөөдөр та бүхэн сургач, оюутан. Гол нь яг сурч байгаа энэ үедээ сайн сураад авбал ирээдүйд түүгээрээ л ялгарна гэсэн үг. Чи ирээдүйд алдар нэртэй, амжилтын эзэн болох эсэх нь өнөөдөр чи сурч чадсан, чадаагүйгээс хамаарна. Түүнээс аав ээж чинь хэн болох, мөнгөтэй, мөнгөгүй, ямар нийгмийн гаралтай байх нь хамаагүй. Ирээдүйг бүтээх нь та өнөөдөр сурч чадах эсэхээс л шалтгаална.

Дарамын Батбаяр “Хүнд хамгаас чухал нь эхлээд сурах хүсэл, тэмүүлэлтэй эсэх, дараа нь сурх зориг зүрхтэй эсэх, эцэст нь яаж сурх арга ухаан олсон эсэх” гэж хэлсэн байдаг. Энэ нь хүнд сурх хүсэл тэмүүлэл байх юм бол сурх зориг зүрх өөрөө ирдэг, үүнд маш их тэвчээр хэрэгтэй, дараа нь яаж сурх гэдэг зүйл гарч ирэхийг хэлж байна.

Боловсрол гэж юуг ойлгох вэ? Тайлбар толь бичгээс та нар хараарай. “Сурахад суралцах”

гэдэг номонд долоон аргын тухай таниулсан байдаг. Хүн ер нь боловсрохоор ямар чадамжтай болдог юм бэ? Энэ их чухал юм.

Хүн дараах 4 цогц чадамжтай байх ёстой:

Шүүмжлэлт сэктэлгээ

Бүтээлч сэктэлгээ

Харилцааны чадвар

Хамтрах чадвар

Мөн маш сайн сураад явбал дараах 6 хандлага хүнд бий болдог юм байна:

Сониуч зан

Санаачилгатай

Туйлбартай

Хөрвөх чадвартай

Манлайлагч

Нийгэм болон соёлын мэдрэмжтэй

Аавын хариуцлага намайг амжилт руу хөтөлсөн

Миний залуу нас: Би 25 насандаа 4 охинтой, 40 насандаа хүүтэй болсон юм. Аав байх хариуцлагаа ухамсарлаж байсан минь өнөөдөр намайг магадгүй ийм амжилтад хүргэсэн байх. Амьдралын маш их зовлон бэрхшээлийг туулсан дурсамж надад бий. Гэр бүлийнхээ төлөө, хүүхдүүдийнхээ

боловсролын төлөө урагшилсан он жилүүд надад тэр бэрхшээл, саадыг даван туулах эрч хүчийг өгсөн. МУИС-д шилдэг оюутны тэтгэлэгтэй 4 жил сурсан, ардчилал, зах зээлд шилжсэн, картын барааны үед ганзагын наймаа ч хийж явсан.


Японд суралцаж Монголын боловсролд шинэ хуудас нээсэн

Зориг гарган 1995 оны 10 сарын 02-нд 32 насандаа эхнэр 4 хүүхдийн хамт Японд суралцахаар явсан минь амьдралдаа хийсэн зоригтой, том алхамуудын нэг байлаа. Тэнд мэргэжил дээшлүүлж, дараа нь магистр, докторт хувийн зардлаар сурсан. Магистрт Японы боловсролыг судалсан. Дайны дараа 1945 оноос өнөөдрийг хүртлэх боловсролын түүх, өөрчлөлт, онцлогийг судалсан. Докторт сурч байхдаа Монголын ахлах сургуулийн сургалт 2 жил байсныг 3 жил болгон өөрчлөх судалгаа хийсэн. Энэ судалгааныхаа үр дүнд өөрийнхөө сургуулийг байгуулсан юм.

Залуудаа худалдаж авсан зовлонгоор аз жаргалтай амьдралыг бутээдэг

“Залуу байхад зовлонг худалдаж аваад амссан ч болно” гэсэн зүйр үг Японд бий.

Би яг залуу насандаа зовлонг худалдаж авч хатуужсан хүн. Японд магистр, докторт сурхад зардал, мөнгө их хэрэгтэй. Бэрхшээл, шантрах үе ч их байлаа. Гэхдээ тэр бүгд түр зуурынх байсан. Хүний нутагт оюутан байсан үеийн минь нэг өдөр ийм байв.



Ганц ажлын цалин бидний амьдралд хүрэлцдэггүй учраас 3-4 ажил хийдэг байсан. Би жил гаруй хугацаанд ингэж ажиллаж, амьдарсан. Миний таньдаг олон япон найз нар намайг "биээ хэмхлэв" гэж хэлж санаа тавьдаг байлаа. Гэхдээ би сагс тоглодог байсан учир өглөөний сонин тараалтаяа гүйлт, оройн ачаа ачихаа фитнесс гэж боддог байсан. Бааранд зөөгч хийхэд хүнтэй их

ярьдаг учир Япон хэлний хичээл гэж бас бодож байв. Ингэж өөрийгөө хөгжүүлэнгээ цалин, мөнгө авч байна гэж өөрийгөө зоригжуулж, урамшуулдаг байв. Тэр ёсоор өөрөө ч хөгжиж, хичээл зүтгэлээ ч үнэлүүлсэн он жилүүд байсан юм. Оюутан залуус маань өөрсдийгөө ингэж хурцалж чадж байна уу, угүй ю?

Эхнэр хятад хоолны газар аяга угаана. Ажил нь шөнө 2 цагт дусаад 3 цагт гэртээ ирнэ. Бид хоёр уулзалгүй хэд ч хонодог байсан юм. Хөөрхий дөө, нэг нь унтаж байхад нөгөө нь ажилдаа зөрөөд явчихна. Бие, биенийхээ унтаж буй царайг л хардаг байсан.

Тэтгэлэгт оюутан болов

Ёнэмагийн нэрэмжит сар бүрийн 1500 ам.долларын тэтгэлгийг Ямагата хойд Ротари клубээс 1 жилийн /1998-1999 он/ хугацаатай авах завшаан тохиосон юм.

Би дээрх 3 ажлыг зэрэг хийгээд 1500 доллар буюу 150.000 иенийн цалин авдаг байсан учир 150.000 иенийн үнэ цэнийг маш сайн ойлгож байв. Би тэр клубын хүмүүст маш их талархаж, мөрөөдлөө биелүүлж, тэдний ачийг хариулахаа амласан. Миний мөрөөдөл

Монголд 3 жилийн сургалттай ахлах сургуулийг байгуулж, олон улсын жишигт нийцсэн "high school"-ийн стандартыг нэвтрүүлэх байв. Тэд миний мөрөөдлийг маш баяртайгаар хүлээж авсан. Том мөрөөдлийг хүмүүсийн өмнө хүчтэй амлах нь чухал юм билээ. "Намайг сургуулиа байгуулахгүй бол та нарыг хулхидсан гэж бодоорой. Гэхдээ би заавал байгуулна" гэж амлаж байсан минь өнөөдрийн амжилтад хүрэх хүчтэй ташуур болсон.

Сургуулиа байгуулсан нь

Ротариийн гишүүд, найз нөхөд маань Багана Нэгийн холбоо байгуулан сургууль байгуулахыг дэмжих хөдөлгөөн өрнүүлж, Ямагата, Сэндай зэрэг хотын 300 гаруй сайхан сэтгэлт хүмүүстүс холбоонд нэгдэн, миний талаар сонинд гарч, ном хүртэл хэвлэгдэв. Ингээд миний мөрөөдлийг дэмжиж, тусалж байсан Япон хүмүүстэй үеийн үед анд байх шалтгаан, хувь тавилангийн түүх эхэлсэн юм. 1999 оноос докторт сурч байхдаа хийсэн судалгаан дээрээ үндэслэн 37 насандaa буюу 2000 онд анх "Шинэ монгол" сургуулиа байгуулж байв. Тэр үед маш олон япон хүмүүс "Чиний мөрөөдөл миний мөрөөдөл шүү, мөрөөдлөө заавал биелүүллээрэй" гэж урамшуулж, хүч өгдөг байв.

Сургуулийн амжилт

Яривал их зүйл бий. Олон төгсөгчид маань гадаадад явж суралцсан. Гадаадад сураад ирвэл боломж их гардаг. Японд гэхэд 424, АНУ-д 74 гээд нийт төгсөгчдийн 33,5% гадаад оронд сурсан тоо бий. Би тэдэнд өндөр боловсролыг гаднаас олж ирээд, мөрөөдөлтэй байж, сурч мэдсэнээ Монголдоо хэрэгжүүлж, эх орноо хөгжүүлж, ачийг нь хариулах хэрэгтэй гэж хэлдэг. Манай төгсөгчдөөс Нобелийн шагналтан төрнө гэдэгт би итгэдэг. Тэдэндээ үргэлж амжилт хүсч, залбирч байгаа.

Төгсөгчдийн өөдрөг хүсэл тэмүүлэл

Эрүүл бие, саруул ухаан, сайхан сэтгэлийг эрхэмлэж явахыг сурагчиддаа захидал. Төгсөгчдөд бол "Та бүхэн сургуулиа төгслөө. Ирээдүйд Монгол орныг нуруун дээрээ үүрч явах удирдагчид болно шүү" гэдгийг л сайн хэлж өгдөг дөө. "Аавынхаа нурууг харж хүүхэд хүмүүждэг" гэсэн үг байдаг. Би бол багш, захирал гэдэг утгаараа төгсөгчдөд сайн нуруу харуулж явахыг хүсдэг. Хүсэл мөрөөдлөөрөө, хийсэн бүтээсэн зүйлтэй байж, үнэ цэнэтэй амьдрахыг зорьж, өөрийн амьдралын туршлагаа тэдэнд ойлгуулахыг хүсдэг юм.

Сурч боловсрохын хэрээр хүн улс, эх орныхоо өмнө үүрэг хүлээдэг. Аав ээжийн ачийг хариулахыг хүсдэг шиг эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахыг ч боддог. Би монгол хүн болж төрөөд, Япон улсад боловсрол эзэмшин, олон хүний дэмжлэгээр мөрөөдлөө биелүүлж, сургуулиа байгуулсан. Эх орондоо ачийг нь хариулахыг туйлын их хүсдэг. Энэ цаг үед амьдарч, багахан ч гэсэн мэдлэг, чадвар, туршлага хуримтлуулсан болохоор түүнийгээ эх орныхоо хөгжилд, ялангуяа боловсролын салбарт хувь нэмэр оруулах нь миний үүрэг болсон.

Би энэ 2019 онд ахин оюутан болсон, Нагоягийн их сургуульд дахин докторт сурч байна. Монголын ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулахын тулд докторт сурч эхэлсэн хэрэг л дээ. Хувийн сургууль байгуулж хуримтлуулсан туршлага дээрээ үндэслэн улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн менежментийг хэрхэн сайжруулах вэ гэдгийг судалгааны үндсэн дээр гаргаж ирэхээр докторт сурч байна.

Би карьераа 2019, 2024, 2030, 2040 гэж төлөвлөсөн байгаа. Өөдрөг байгаа биз. Санаж төлөвлөж явбал бүтдэг шүү дээ. 2040 онд манай сургуулийн төгсөгчид нийгэмд хийсэн бүтээсэн зүйлтэй, өөрийнхөө байр сууриа эзэлсэн удирдагчид болсон байхаар төсөөлж буй.

Эцэст нь та нарыг өөрсдөөсөө дараах асуултыг асууж байгаасай гэж хүсч байна.

Чи сурахыг жинхэнээсээ эрхэмлэж чадаж байна уу?

Суръя, хөгжье гэсэн чин хүсэл эрмэлзэл байна уу?

Юунаас ч шантрахгүйгээр сурах зүрх зориг байна уу?

Сурах арга барилаа олж чадсан уу?

Ирээдүйн амьдралаа өөрөө бүтээж чадна гэдэгтээ итгэлтэй байгаа юу?

Эдгээр асуултыг өөрөөсөө нэг нухацтай асууж, хариулаад үзээрэй. Энэ асуутад хариулж чадвал сурахыг эрхэмлэдэг болно. Түүгээр ч барахгүй түүний шагнал, үр дүнг хүртэж чадна. Та нарт амжилт хүсье.



БОЛОМЖГҮЙ ГАЗАР БОЛОМЖ БАЙДАГ

Г.ГАНТУЯА

“Номадик контент” үүсгэн байгуулагч

Сайн байцгаанаа уу?

Өнөөдрийн та нарт ярих сэдэв бол "Боломжгүй газарт боломж байдаг" тухай юм.

Сэдвээ эхлэхийн өмнө та нараас нэгэн зүйл асууя. 15 жил ажиллахад цалингаа 150 дахин өсгөх боломж бидэнд бий болов уу?

Мэдээж байгаа гэж хэлье. Би анх 2001 онд ажилд ороход 100 мянган төгрөгийн цалинтай байв. Харин 15 жилийн дараа 15 саян цалинд хүрлээ. Энэ бол нийгмийн даатгалын дэвтэр дээрх Монгол Улсад татвараа төлсөн бодит тоо юм.

Үүнд хэрхэн хүрсэн нь та бүхэнд сонирхолтой байж магад. Би бол Монгол Улсад данстай Ганбургэдийн Гантуяа. Аав, нөхөр, гурван хүүхдийн хамт амьдардаг, эгч, дүү зургуулаа иргэн хүн.

Би хэрхэн бүтсэн бэ?

Миний хүүхэд нас зах зээлд дөнгөж шилжсэн үед гэр бүлээрээ суманд амьдарч байхад өнгөрсөн. Зах зээлийн үед хувьчлалаар өгсөн 50 орчим хонь, 5 орчим тугалтай үнээг эгч, дүү зургуулаа ээлжлэн хариулж, гэрийн үүрэгт ажлаа ээлжлэн хийцгээдэг байв. Ээж,

аав төрийн албан хаагч тул завгүй. Харин миний хувьд гурван дүү, эмээгээ асарна. Энэ бол бидний хүүхэд ахуйн амьдралын дүр зураг. Мэдээж би эдгээр ажлын хажуугаар хичээлдээ явна, гар бөмбөгийн дугуйланд суралцана, сайн дурын ажил хийнэ, чөлөөт цагаараа кино үзнэ, хөгжим сонсоно, гадаа тоглоно.

Эндээс миний хэлэх гээд байгаа санаа юу гэхээр хүмүүс нэг л зүйл рүү хэт их төвлөрөх нь бий. Энэ тэнцвэр алдагдахаараа бидний өв тэгш, өсөж хөгжих боломж хясагддаг гэсэн үг.

Тиймээс бүхнийг тэнцвэртэй, тунг нь тааруулж хийж сурах, мөн гэр булийнхээ үүрэгт ажлаа таатай хүлээж авч гүйцэтгэх нь бидэнд нэмэлт ур чадваруудыг суулгадаг. Магадгүй та нар хичээл ихтэй гээд бусад ажлаас татгалздаг байж магад. Гэтэл энэ нэмэлт ажлууд нь биднийг бие хүн болгож, нийгэмших боломж олгож, хүмүүстэй харилцах чадвар суулгаж, нөгөө талаасаа оюун санааны хөгжлийг өгч байдаг.



Ямар ч ажлыг гололгүй хийснээр

Цаг төлөвлөлт, ашиглалт

Дасан зохицох, хөрвөх

Тасралтгүй суралцах

Туслах, дэмжих

Бэрхшээлийг даван туулах

Хоббитой байх

Багаар ажиллах

Сонсох, хүндлэх

Эелдэг нөхөрсөг байх

*Хөдөлгөөнтэй байх зэрэг
төлөвшлийг өөртөө бий
болгодог.*



Аливаа ажлыг хийх цагаа тооцдог, олон зүйлийг хийгээд сурчихсан хүн ирээдүйд ажил дээр цагаа зөв ашигладаг, ямар ч ажлыг хийж чаддаг. Мөн бусдад туслахын сацуу нийгэмд идэвхтэй хүн болж, бэрхшээлийг даван туулах, багаар ажиллах, бусдыг сонсож сурах, эелдэг байх, идэвхтэй байх, зөв зугаацан цэнгэх чадвартай болдог. Та бүхэн

хүн амжилттай явах үндэс нь сайн боловсрол гэж ойлгож магад. Гэтэл үгүй юм. Харин бие хүний төлөвшлийн асуудал билээ.

Миний боловсрол:

Би Төв аймгийн Жаргалант суманд төрж, Цээл, Угтаалцайдам суманд өсөж, 10 жилийн сургуулиа дүүргэсэн. Үүнээс хойш доорхи байдлаар сургалт, хөгжлийн замаар явж байна.

1986-1996 онд Төв аймаг, ерөнхий боловсролын дунд сургууль

1996-2001 онд ШУТИС, Компьютер, техник, менежментийн сургууль, мэдээлийн системийн инженер

2013-2015 онд ШУТИС, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль, бизнесийн удирдлагын магистр

2015 онд Сэтгүүл зүйн дээд сургууль, Сэтгүүл зүйн удирдах ажилтан

2018 онд ШУТИС, БАТС Бизнесийн удирдлагын докторант

Дээрх түүхээс юу хэлэх гээд байна гэхээр хүн ажлаа хийнгээ тасралтгүй суралцах хэрэгтэй. 4 жилийн мэдлэгийг насан туршийн мэдлэг гэж бодож болохгүй. Ялангуяа дэлхий

маш хурдтай хөгжиж байгаа учраас жилд нэг удаа гадаад, дотоодын богино хэмжээний сургалтад заавал явах ёстой. Ингэснээрээ менежментийн болон хэлний ур чадварт суралцана. Суралцах гэдэг бол тасралтгүй юм шүү дээ.

Би анх 1996 онд сургуулиа төгсөөд мөрөөдлөө биелүүлэхээр багш болох боломжтой байсан ч миний сонголт программ хангамжийн инженер байв. Та нар давхар мэргэжил эзэмших бүрэн боломжтой. Хэрвээ нэмэлт мэргэжлээр сурахаар бол ирээдүйн 10 жилд монголд болон дэлхий дахинд хэр эрэлттэй байгаа эсэхийг харах, түүнчлэн цалин хөлс үнэлэмж нь ямар байна гэдгийг тооцоолж мэргэжлээ сонговол их зүгээр. Өөрийн мөрөөдсөн мэргэжил нь тухайн улс оронд илүүдэлтэй мэргэжил байх, түүнчлэн цалин хөлсний үнэлэмж бага байвал сонирхсон мэргэжлээ түр хойш тавиад, амьдралд хэрэгтэй мэргэжил сонгох нь чухал болов уу.

Амьдралын дараагийн замналаа та бүхэнд ярьж өгье.

Миний хувьд ажил эрхлэлтийн явц б үе шатыг дамжсан:

2001 онд контент оператор, төслийн ахлагч /Шинэ бизнесийн хэлтэс, Мобиком корпораци/

2005 онд менежер /MBS бизнесийн хэлтэс, "Монгол Контент" ХХК/

2008 онд менежер /Мобайл бизнесийн хэлтэс, "Монгол Контент" ХХК/

2009 онд менежер /Медиа ГоГо бизнесийн хэлтэс, "Монгол Контент" ХХК/

2011 онд захирал /ГоГо бизнесийн алба болон мэдээлэл Технологийн алба, "Монгол Контент" ХХК/

2014 онд гүйцэтгэх захирал /"Монгол Контент" ХХК/ зэрэг ажлуудыг хийж байсан.

2018 онд ерөнхий захирал /Номадик контент/, өөрийн компанийг үүсгэн байгуулсан.

Та бүхэн сайн харвал ажлын гарaa анхан шатны түвшнээс эхэлсэн байгаа. Өнөөдрийн энэ амжилтад алхам алхмаар хүрсэн бөгөөд миний өмнө ярьсанчлан хүүхэд байхад хийж дадсан ажлууд болон ямар ч ажлыг голохгүй хийх чанар, хэнтэй ч дасан зохицон ажиллах чадвар, багаар ажиллаж, тасралтгүй сурсан явдал их нөлөөлсөн юм. Эндээс харахад хүн

зөвхөн авьяас, ур чадвартай байхад амжилтад хүрдэггүй, хувь хүний төлөвшил, хандлага, харилцаа гурав заавал нөлөөлдөг гэдгийг та бүхэнд хэлэхийг хүсч байна.

Бидэнд ажил хөдөлмөр хийгээд явж байхад санхүүгийн хувьд чадавхаа өсгөх хоёр боломж байдаг гэж би хувьдаа боддог.

- 1. Нарийн мэргэжлийн үр чадвараа хөгжүүлэх замаар мэргэшсэн хүн болох**
- 2. Алхам алхамаар албан тушаал өсөж туршилагажих замаар удирдах ажилтан болох**

Ямар замаар явахaa хүн бүр дунд хугацаанд төлөвлөж байгаарай.

Жишээ нь, намайг хүүхэд байхад хөдөөний хүүхдүүдийн англи хэлний мэдлэг маш муу, хотын хүүхдүүд сайн байсан. Би гадаад явахгүй бол сурахгүй, эсхүл надад хэл сурах зав байхгүй, санхүүгийн боломж муутай, одоо сурах нас өнгөрсөн гэх мэт шалтаг хэлээд сурахгүй байж болох л байсан. Гэхдээ миний тухайн үед харсан зүйл бол би хэл сурахгүйгээр нэг алхам ч урагшилж

чадахгүй, өнөөдрийн хүрсэн байрнаасаа ч ухрах магадлалтайг олж харав. Ингээд өөртөө цаг гаргаж, сурч чадна гэдэгт итгэж эхэлсэн. Боломжгүй газар боломж байдаг гэдгийн нэг жишээ бол хэл сурах алхам. Хэрвээ бид бүх зүйлийг боломжгүй гээд байвал юу ч хийж чадахгүй. Англи хэлийг заавал гадаад явалгүйгээр гэртээ, ажлаа хийж байхдаа сурах боломжтой. Та бүхэнд боломж байгаа, тасралтгүй сурч өөдөө алх, жилд нэг зүйлийг заавал шинээр сурах хэрэгтэй.

Ажил сонголтын талаар миний өгөх зөвлөгөө бол:

Тухайн компани нь:

Өсөлттэй болон өсөх ирээдүйтэй
Таныг удирдах шууд удирдлагыг сайн судлахыг хичээх
Анхан шатны албан тушаалаас нь эхэлж байвал бүр л сайн, чамлах хэрэггүй
Сургалт хөгжлийн систем, бодлогыг харах
Карьер хөгжлийн систем, бодлогыг харах
Цалин хөлсний систем, бодлогыг харах

Ажлыг сонгоходоо тухайн компани хэр өсөлттэй бизнес эрхэлж байгааг харахыг хичээгээрэй.

Шууд удирдлага нь таны хүсэл эрмэлзэл, ирээдүй, зорилготой нийцэх, хамтарч ажиллах боломжтой эсэхийг нягтлаарай. Тухайн компанийд орохдоо анхан шатны албан тушаалаас эхэлбэл бүх ажлыг сайн хийж сурдаг тул ирээдүйд удирдах ажилтан хийхэд их нэмэр болдог юм. 4 жилийн сургалт насан туршийн сургалт биш учраас ажлын гараан дээрээ хүн маш их зүйлийг сурдаг. Тасралтгүй сурч байж хүний мэдлэг өргөждөг. Анхан шатнаас нь ороход 5 жилийн дараа ахлах, 10 жилийн дараа менежер болох карьер хөгжлийн зам таны хувьд байна уу гэдгийг сайн харахыг хичээх хэрэгтэй.

Тухайн компаний алсын хараа, зорилго, үнэт зүйл ямар байна, олон улсад яж үнэлэгддэг вэ, салбар, өрсөлдөгч компани нь ямар ямар компани вэ гэдгийг өөрсдийн төвшинд судлан мэдэх хэрэгтэй. Энэ б сонголтыг хийсний дараа ажлаа сонгоорой.

Ажлын гараагаа хаанаас эхлэхээс шалтгаалж ирээдүйн ажил хөдөлмөрийн карьер нь тодорхойлогддог. Анхны компани таны хүсэл мөрөөдөлтэй нийлэхгүй цалин хөлс нь сэтгэлд нийцэхгүй бол өөр боломж хайх хэрэгтэй.

Монголд: Мэргэжил+Цалин = Сайхан ирээдүй

Миний хувьд анх ажилд орсон өдрөөсөө "контент" гэдэг үгтэй холбогдож ирсэн. Эхний 6 жил гар утсанд зориулсан контент хөгжүүлж байсан бол технологийн хөгжлийг даган gogo. mn төслийн багт ажилласан. Үүний дараанаас гадны улс орны хүүхдийн контент манайд орж ирсэн үед монгол хүүхдийн ирээдүй, монгол иргэн болгохын төлөө хүүхдийн контент буюу "Ногун", "Yolo", "Maamuу", "Ботгоон" зэрэг олон төсөл хэрэгжүүлж байсан. "Maamuу" төслийг 2016 онд зах зээлд байршуулсан. Анх "Maamuu" төслийг нэвтрүүлж, Монголд үндэсний хүүхэлдэйн кино хийе гэхэд эцэг эхчүүд, телевизүүд монголд хүүхэлдэйн кино хийж чадахгүй, гадны орны хүүхэлдэйтэй өрсөлдөж чадахгүй гэж няцааж байсан. Харин бид өөртөө итгэлтэй байсан учраас "Бид чадна аа" гээд хүүхэлдэйн киногоо бүтээсэн бөгөөд өнөөдрийн байдлаар YouTube 100'000 дагагчтай, хэдэн сая үзэлттэй, үндэсний том контент болж чадсан билээ. Эндээс харахад

**Хүмүүсийн “Боломжгүй” гэсэн зүйл
рүү илүү гүн орж судалж, төлөвлөгөө
сайтай зутгээд үзэхэд ажиллахад
асар их боломж байдгийг мэдсэн.**

Би энэхүү илтгэлээрээ та бүхэнд ажлын гараагаа зөв сонголтоор эхэлж, тасралтгүй суралцсанаар ур чадвараа нэмэгдүүлж, ирээдүйд цалингаараа сайхан амьдрах боломжтой гэх урам зориг өгөхийг хичээллээ.

Та бүхэнд амжилт хүсье!

Энэхүү нүсэр контент үйлдвэрлэлийн хажуугаар нийт 20 гаруй томоохон програм хангамжийн платформ хөгжүүлснээс анх удаа 2017 дэлхийн зах зээл дээр гарч, Монгол залуусын үнэлээмжийг өсгөсөн билээ.

Мөн сүүлийн жилүүдэд урлагийн салбарт олон улсын стандарт нэвтрүүлэх оролдлогууд хийсэн бөгөөд Монголд хөгжмийн уран бүтээлийг оюуны өмчийн зөвшөөрөлтэй ашигладаг гэдэг соёлыг нэвтрүүлж, нутагшуулж чадсан юм. Харин кино урлагийн салбарт 7 кинонд продюсер хийж, хөгжмийн салбарт цөөнгүй тоглолт зохион байгуулсан. Ийнхүү тасралтгүй сурч, зах зээлийн эрэлт хэрэгцээг дагаж, хайгуул хийсээр мэдээлэл технологи, хэвлэл мэдээлэл, соёл урлаг, боловсрол, зар сурталчилгаа-пиарын чиглэлээр өөрийнхөө ур чадварыг алхам алхмаар тэлсээр байна .





АМЖИЛТАЙ ОЮУТАН–ИРЭЭДҮЙН МАНЛАЙЛАЛ

“Эм Эн Маркетинг консалтинг” үүсгэн

Сайн байцгаанаа уу? “Тулаанд шонхрууд ялдаг” гэдэг шиг энд тэсвэртэй, тэвчээртэй, ирээдүйнхээ төлөө эзэн болох гэж байгаа зорилготой залуус надтай үлдсэн гэж бодож байна. Тийм учраас бүгдээрээ бидэнд олгогдсон богинохон цаг хугацааг хамтдаа гайхамшигтай өнгөрөөнө. Учир юу вэ? гэвэл өмнөх илтгэгчид салбар салбартaa тэргүүний, эх орныхоо хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан, ирээдүйг минь цогцлоож өгсөн хүмүүс. Тэгвэл дараагийн үе би, тэрнээс хойш та нарын үе ямар байх талаар санал солилцоод ганц хором ярилцъя.

“Амжилттай оюутан -Ирээдүйн манлайлал” сэдвийг та нартай ярилцахаар сонгож авлаа. Энэ сэдвээр хэдэн онд анх илтгэл тавьж байсан гэж бодож байна? 2007 онд ШУТИС-ийн төгсөх ангийн оюутан байхдаа сургуулийнхаа оюутнуудад илтгэлээ тавьж, өөртөө итгэлтэй болж байсан цаг үе. Тухайн үед бид оюутнууддаа амжилттай, үр дүнтэй суралцах, чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх, харилцааны соёлтой, ажил хэрэгч соёлыг түгээх олон талт нөлөөллийн ажлуудыг санаачлан гүйцэтгэж байжээ.

Сургуулиа төгсөөд би “Тэди” төвд үйлчилгээний ажилтнаар ажилд орж байлаа. Дараа нь Мобикомын залуусын оролцоог дэмжигч “Ве брэнд”-ийг үүсгэн байгуулахад хүчин зүтгэж, Мобиком гэдэг тэр том брэндийн маркетингийн багийг ахлан ажиллаж байсан. Би Мобикомд нийтдээ 12 жил ажилласан. Ажиллаж байх хугацаандаа Тайваньд суралцан, магистрын зэрэг хамгаалсан.

Хувь хүний брэндинг гэж юу юм бэ?

Амжилт гэдэг бол таны эргэн тойронд байгаа, таныг үргэлж дагаад явж байдаг зүйл гэж боддог. Бид амжилтыг гарaa урагш нэг сунгаад атгаад авах боломж байхад заримдаа шантраад алдчих гээд байдаг. Гэхдээ хүн бүрт амжилт байгаа. Өглөө бүр 6 цагт сэргүүлэг тавьж босдог байснаа гэнэт өөрөө түрүүлээд босдог дадал хэвшилд сурч чадвал энэ амжилт. Амжилтыг албан тушаал, нэр хүндтэй албан байгууллага, эсрэгээрээ az жаргалтай анхны хайр, үнэнч үерхэл, нөхөрлөл бүтээдэг байх. Амжилтыг бид өөр өөрийнхөөрөө бүтээдэг.

2007 онд ШУТИС-ийн оюутан байсан залуу өнөөдөр эх орныхоо ирээдүйн суурийг бий

болгох оюутан залуустай уулзах хүртлээ ямар дүр төрхтэйгээр, яж өөрийгөө хурцалж явж байсан бэ? Би аль болох өөрийгөө ямар ч цаг хугацаанд дандаа хүчирхэг байлгаж, өөртэйгээ тулж ажилладаг байсан юм.

Залуучууд минь өнөөдөр хүчирхэг, жинхэнэ, хувь хүний брэндийг үүсгэх ёстай. Би энд өнөөдөр гоё зүйл ярьчихаад бусад үед өөр хүн байж болохгүй. Ярьсан шигээжинхэнэ, хувиршгүй байх ёстай. Мэдээж харагдах байдал чухал. Эцэст нь үнэ цэнэтэй байдлаа хадгалсан хүн байгаарай залуусаа. Монголын ирээдүй, маргаашийг авч явах залуучууд учир та бүхэн өөрсдөдөө, бусдадаа амжилт хүсээрэй.

Амжилтын сэтгэл зүй, хувь хүний амжилтыг бүтээхэд дэм болох 10 ур чадварыг та бүхэнтэй маш товчхон хуваалцъя.

1. Өөрийгөө таныж мэдэх. Өөрийнхөө зан чанар, бусдын сэтгэл хөдлөл зэргийг ойлгох чадвар юм. Магадгүй чамд цаг хугацаа, орон зайн ямар ч асуудал гарсан толинд хараад өөрийгөө зоригжуулж бай. 5 жилийн дараа чи хэн болох, 10 жилийн дараа ямар байх юм гэдгээ өөрөөсөө асууж,

үүнийхээ төлөө зогсолтгүй тэмцдэг байх зан чанарыг өөртөө хэвшүүлээрэй.

2. Зорилго тодорхойлох. Уулын оргил руу амжилтад хүрэхээр хүн бүр тэмүүлдэг. Зорилго тавьж, алхам алхмаар урагшилж байж оргилд хүрдгийг та нар мэдэж байгаа. Өнөөдөр энэ танхимаас ганц "гоё", "галзуу" санаа олоод харьж чадвал бидний өнөөдрийн үйл ажиллагааны зорилго биелнэ. Магадгүй өнөө өглөө сэрээд Улаанбаатар палас руу явах уу, буцаад унтах уу гэж өөрөөсөө асуусан байх. Унтаад үлдсэн залуус бол боломжийг алдаж, харин амжилттай яваа залуус бусдаас түрүүлж алхдаг. Амжилттай залуус гэдэг бол бусдыг унтаж байхад хичээлээ хийж байдаг, бусдыг амарч байхад ажиллаж байдаг. Та бүхнээсээ амжилттай залуу байхыг хүсч байна.



3. Өөрийгөө хөгжүүлэх Бусад хүмүүс чамд шүүмжлэлтэй ханддаг бол түүнд баярла. Хэдэн жилийн дараа яаж явахаа харуулнаа гэж өөрийгөө зоригжуулах амьдралын зорилготой байгаарай.

4. Амжилтын сэтгэл зүй Бидний сургалтын төлбөрийг төлөх гэж аав, ээж яаж ажиллаж, хөдөлмөрлөдөг билээ. Тэгвэл тэр цаг хугацааны төлөөсийг төлөхийн тулд сайн хүн болж, сайн суралцах нь нэн тэргүүний зорилго мөн үү? Мөн. Гэхдээ бид 4 жил суралцаж, төгсөөд дипломоо авах нь нэн тэргүүний зорилго.


2012 онд би Тайвань руу суралаар явсан. Эхлээд хэл ус сайн нэвтрэлцэхгүй хэцүү байсан ч би өдөр бүр хичээлээ нухаж, 30 хэмийн халуунд сургуулийнхаа талбайг тойрч хөлсөө урсгаж, эрч хүчээ олж авдаг байсан. Юунд хөлсөө урсгаад байна гэвэл, Тайваньд 2 жил сураад магистрын диплом өвөртөлж ирэх зорилго юм. Гадаадад олон залуучууд суралаар явдаг. Зарим нь нөгөө гарaa сунгаад авчих боломжийнхоо захад очоод шантраад, зорилгоо биелүүлж чадахгүй, дипломгүй ирдэг.

Бид оюутны клубээрээ дамжуулж тухайн үеийн нэр нөлөө бүхий, оюун санааны тэсрэлт хийж болох эрхмүүдээр 7 хоног бүр лекц үншуулж, оюутнуудтайгаа уулзуулдаг байсан. Өнөөдөр та бүхэн ирээдүйн төлөө залуучуудын оролцоо, боломжийг өөрсдөдөө бий болгох гэж ирсэн. Залуучууд та бүхэндээ баярлаж байна.

5.Хувийн зохион байгуулалт Амжилтын сэтгэл зүйтэй, амжилтын төлөө явж байгаа бол хувийн зохион байгуулалт сайн байх ёстой.

6.Зөв харилцаа. Багш нарынхаа арга эвийг олдог, найз нөхдөө эвлэрүүлдэг, анги хамт олондоо нэр хүндтэй, хэн нэгэнд хаалга нээгээд өгдөг, мөрлөөд өнгөрөхөд учлалт гүйдаг, энэ бүгд зөв харилцааны суурь юм.

7.Өөрийгөө илэрхийлэх. Үл ойлголцох зүйл дээр бусдын өнцгөөс асуудалд ханддаг, аливаа зүйлийг хоёр талаас нь хардаг байгаасай гэж хүсч байна. Бусдыг ойлгодог мэдлэг чадвартай байгаарай.



8. Social харилцаа. Бусадтай тогтоосон харилцаа холбоогоо алдахгүй байх. Би 2007 онд сургууль дээрээ урьж, илтгэл, яриа, таниулга хийлгэж байсан хүмүүстэйгээ одоо хүртэл холбоотой байдаг. Хэн нэгэнтэй тогтоосон харилцаа холбоогоо битгий мартаарай. Энэ маань өөрөө үнэ цэнэтэй байдлыг бий болгодог.



9. Бүтээлч байдал. Энэ хамгийн чухал нь. Аливаа юмыг өөр өнцгөөс, олон талаас нь харж, шинэчилж, өөрийгөө чөлөөлж, бусдаас

ялгаруулж байдаг зан чанар дээрээ төвлөрөх хэрэгтэй.

10. Хандлага. Бүгд эерэг хандлагаар, ирээдүйд манлайлна. Залуу хүн бүр нийгмийн идэвхтэй амьдаръя. “Монголын залуучуудын холбоо”, “Маркитенгийн холбоо”, “Нутгийн зөвлөл”, “Тайваньд төгсөгчдийн холбоо” энэ бүхэнд би цаг, заваа зарцуулж, оролцоотой байдаг. Чиний нөлөөлж болох, оролцож болох орон зай юу байна, тэнд очиж асаж, дүрэлзэж, дуу хоолойгоо өргөж байгаарай залуучуудаа гэсэн уриалгаар өндөрлөе. Олон олон залуусын амьдралд өөрчлөлт авчрах гэгээн хүсэлтэй байгаарай залуусаа.

Баярлалаа.





ШУДАРГА ЁС-ХӨГЖИЛ ДЭВШИЛД

110 

ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ УТАС
/үнэ төлбөргүй/



АВЛИГАТАЙ
ТЭМЦЭХ ГАЗАР